

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

2018.03.29

Зуунмод сум

Төв аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газрын Баянчандмань, Угтаал цаг уурын өртөөнд “Техникч”-ийн байнгын ажлын байр, Эрдэнсант цаг уурын өртөөнд “Техникч”-ийн түр ажлын байранд тус тус 1 орон тоо гарсан тул ажилтан шалгаруулж авна.

Нэг. Тавигдах шаардлага:

Боловсрол: Дээд боловсролтой /Бакалавр/

Мэргэжил: Цаг уурын инженер, цаг уурын техникч

Мэргэшил: Цаг уурын техникчийн курс болон сургалтанд хамрагдсан мэргэжлийн үнэмлэхтэй

Ур чадвар: -Компьютерийн хэрэглээний программыг эзэмшсэн байх

- Албан хэрэг хөтлөлтийн талаар зохих мэдлэгтэй
- Багаар ажиллах чадвартай
- Харилцааны өндөр соёлтой
- Ажлын ачаалал даах, хариуцлага хүлээх чадвартай

Хоёр. Давуу тал:

- Төрийн болон Цаг уурын байгууллагад ажиллаж байсан ажлын туршлагатай
- Спорт, урлагийн авъяастай
- Англи, орос хэлний зохих мэдлэгтэй

Гурав. Бүртгүүлэх иргэн дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

1. Төрийн албан хаагчийн анкет №1-ийн дагуу бүрэн бөгөлсөн, цээж зураг наасан байна.

2. Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /дипломын хуулбар/

3. Мэргэшүүлэх сургалтанд хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн хуулбар

4. Иргэний үнэмлэхний хуулбар

5. Ажилласан хугацаа болон ажил эрхлэлтийг гэрчлэх баримт /Нийгмийн даатгал, хөдөлмөрийн дэвтрийн хуулбар/

Дээрх шаардлагыг хангасан иргэдийн баримт бичгийг Төв аймгийн Баянчандмань, Угтаал, Эрдэнэсант цаг уурын өртөөдийн ажлын байранд 03 дугаар сарын 29-нээс 04 дүгээр сарын 05-ны өдөр хүртэл ажлын 5 хоногийн хугацаанд хүлээж авна.

Баримт бичгийг дутуу бүрдүүлсэн иргэнийг бүртгэхгүй.

Дөрөв. Мэдээлэл лавлагаа

Ажлын байртай холбоотой асуудлаар

-Төв аймгийн УЦУОШГ-ын 70273864,

-Баянчандмань цаг уурын өртөөний 70276304, 99949472,

-Угтаал цаг уурын өртөөний 70276940, 99609828,

-Эрдэнэсант цаг уурын өртөөний 93016257 96263350 дугаарын утсаар холбогдож лавлагаа авч болно.